



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



ХӨГЖИМ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ.
- (*) тэмдэгтэй даалгавруудыг хөгжим болон дуу сонссоны дараа гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн хариултаас зөвхөн нэг хариултыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

***М.Равель “Болеро” зохиолын хэсгээс сонсоод 1-6 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

- *Дан хөгжмийн ямар төрлөөр бичсэн байна вэ? Тохирох хувилбарыг сонгоно уу.
 А. Этюд В.Серенада С.Сонат D. Симфони
- *Хөгжмөө анхааралтай сонсоод, аялгууны хурдад тохирохыг сонгоно уу?
 А. удаан В. хурдан С. дунд зэрэг D. яаралгүй
- *Хөгжмийн зохиолчийн илэрхийлэхийг зорьсон санаатай аль нь тохирч байна вэ? Сонгоно уу.
 А. Испани ардын бүжгийн онцлог, хэв шинжийг агуулсан үндсэн сэдэв ая өөрийн гэсэн давтагдашгүй төрхөөр эгшиглэдэг.
 В. Зохиолд сэтгэл хөдөлгөсөн үг хэллэгийн яруу тод уншлага, бодит хашхираан болгоныг ноот болгон буулгахыг зорьсон.
 С. Зохиолд эрт эдүгээгийн хөгжмийн олон янз хэв маяг, дуулах арга барил тусгагдсан бөгөөд үүгээрээ тодорхой зүйлийг бэлгэдсэн.
 D. Хүний амьдралын мөн чанар болох зогсолтгүй эргэлдэх хөдөлгөөн мөнхийн зөрчил тэмцэл, хувьсал өөрчлөлтийг илэрхийлэхийг зорьсон.

Ноот бичлэгийг ажиглаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

- *Асуултын тэмдгийн оронд тохирох айзам хэмжээг сонгоно уу.





- A. B. C. D.

- *Ноот бичлэгийг ажиглаад, аялгууны хөдөлгөөнд тохирох зураглалыг сонгоно уу.



- *Хөгжмөө анхааралтай сонсоорой. Эхний хэсгийн гол аяыг ямар хөгжмөөр хөгжимдөж байна вэ?



***Ш.Өлзийбаяр “Дөрөө” зохиолын хэсгээс сонсоод 7-10 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

7. *Бүжиг дэглээч монголын уламжлалт бүжгийн ямар төрлийг орчин үеийн модерн урсгалтай хослуулсан байна бэ?
 А. Сугсраа В. Бий биелгээ С. Чичиргээн D. Цохилго

8. *Ноот бичлэгийг анхааралтай ажиглаарай. Тодруулсан ноотны ард байгаа цэгийн үүргийг зөв тайлбарласныг сонгоно уу.



- А. Тухайн эгшгийг хагас өнгөөр дээшлүүлэх үүрэгтэй.
 В. Тухайн эгшгийг хагас өнгөөр доошлуулах үүрэгтэй.
 С. Түр зогсох үүрэгтэй.
 D. Тухайн ноотны талтай тэнцэх хэмжээгээр уртасгах үүрэгтэй.
9. *Хөгжмийн аялгууны хурд чинийхээр ямар байсан бэ?
 А. Presto- Хурдтай В. Adagio- Удаан
 С. Andante- Тайван D. Allegretto- Хурдавтар
10. *Хөгжмийн зохиолчийн илэрхийлэхийг зорьсон санаатай аль нь тохирч байна вэ? Сонгоно уу.
 А. Хүмүүний амьд явахын үнэ цэн, эх дэлхий, байгаль орчноо хамгаалахын утга учир, гэгээн хайрын хүч, эрхэм дээд хүмүүний ёс суртахуун
 В. Хүний амьдралын үхэх, төрөхийн мөчлөг, үйл үрийн уялдаа холбоог тусгасан.
 С. Шувууд эх байгальдаа баясан цэнгэж, хосоороо бяцхан ангаахайнуудтайгаа ямар их аз жаргалтай байдгийг илэрхийлжээ.
 D. Орчин цагийн залуусын үерхэл нөхөрлөл, хайр сэтгэл, гэр бүл, эцэг эх, үр хүүхдийн бие биеэ харилцан хүндлэх нандин холбоо, ёс суртахууны эрхэм чанарыг дэвшүүлсэн.
11. Монголын хөгжмийн театрын түүхэн дэх анхны модерн бүжгэн жүжиг аль вэ?
 А. “Дөрөө” В. “Зуурдын орон”
 С. “Эх дэлхийгээ аварцгаая” D. “Шар тэнгисийн тарчлаан”
12. Нэг аялгууг олон янзаар хувирган хөгжүүлж, давтах маягаар зохиосон хөгжмийн зохиолын хэлбэрийг гэнэ.
 А. Додекафони В. Вариаци С. Бодит хөгжим D. Магтуу
13. Эстрад урлагийн төрлийг хөгжмийн зэмсгүүдтэй нь зөв харгалзуулсныг сонгоно уу.
 1. Жазз а. Төгөлдөр хуур
 2. Рок б. Банжо
 3. Кантри с. Гитар
 4. Регтайм d. Саксафон
- А. 1d 2c 3a 4b В. 1d 2c 3b 4a С. 1c 2b 3a 4d D. 1c 2b 3d 4a

14. Хөгжмийн урсгалыг тодорхойлолттой нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

- | | | |
|-------------------|----|--|
| 1. Авангардизм | a. | Францаар сэтгэгдэл гэсэн утгатай. XIX зууны эхээр өрнө дахины урлагт гарсан орчин үеийн уран сайхны нэг чиглэл |
| 2. Бодит хөгжим | b. | Илэрхийлэл гэсэн утгатай латин үг. Хүмүүсийн эмгэнэлт хувь заяаны жинхэнэ мөн чанарыг нээхийг эрмэлзэж байсан. |
| 3. Экспрессионизм | c. | Тэргүүн хэсэг манлайлах гэсэн утгатай. Хөгжмийн эгшгийн оронд амьдрал дээрх тодорхой дуу авиа, чимээ шуугианыг ашиглаж шинэ хөгжим бүтээх арга |
| 4. Импрессионизм | d. | Хөгжмийн эгшгийн оронд амьдрал дээрх тодорхой дуу авиа, чимээ шуугианыг ашиглаж шинэ хөгжим бүтээх |




A. 1a 2c 3d 4b

B. 1c 2d 3b 4a

C. 1c 2b 3a 4d

D. 1d 2a 3b 4c

15. Орчин үеийн бүжгийн төрлийг зурагтай нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

- | | | |
|----|---|--------------|
| 1. |  | a. чарльстон |
| 2. |  | b. самба |
| 3. |  | c. танго |

A. 1b 2a 3c

B. 1a 2c 3b

C. 1c 2a 3b

D. 1a 2b 3c